

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ
МЭДЭГДЭЛ, 2023-2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН
МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2021 оны 10 дугаар
сарын 19-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Төсвийн байнгын хороо 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Засгийн газраас Дэлхий нийтийг хамарсан коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын дараах улс орны эдийн засгийг эрчимтэй сэргээх зорилтыг хангах, хөдөлмөр эрхлэлт, бүтээмжийг нэмэгдүүлэх, эдийн засгийг төрөлжүүлж, дунд хугацааны эдийн засгийн өсөлтийг тогтворжуулах төсөв, санхүүгийн шинэчлэлийн бодлогын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуульд заасан эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд өөрчлөлт оруулахаар хуулийн төслийг боловсруулсан байна.

Байгалийн баялгаас олох орлогын хүртээмжийг нэмэгдүүлж, улс орны ирээдүй болсон хүүхдүүддээ хуримтлалын ач тусыг ойлгуулж, санхүүгийн баталгаатай, мэдлэг боловсролтой иргэн болж төлөвшүүлэх зорилгоор Ирээдүйн өв сангийн тухайн жилийн орлогын эх үүсвэрийг арилжааны банкн дахь хүүхдийн нэрийн дансанд байршуулах, Ирээдүйн өв сангийн төсвийг нэгдсэн төсвийн бүрэлдэхүүнд хамааруулах, мөн орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр, зарцуулалтын хуваарилалтад зарим өөрчлөлтийг оруулахаар Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулжээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд эдийн засгийн үндсэн үзүүлэлт, орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийн зарцуулалтын хуваарилалтад оруулах өөрчлөлтийн талаар, мөн ирээдүйн өв сангийн зарцуулалт, цаашид ямар төсвийн бодлого баримталж ажиллах талаар, ирэх жилүүдийн төсвийн төсөөллийн тооцоолол бодитой эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн орон нутгийн хуваарилалтыг хийхдээ уул уурхайн үйлдвэрлэл явуулж байгаа, байгаль орчин эвдэгдэж байгаа аймаг, сумдад илүү

хуваарилах нь зүйтэй бөгөөд тооцооллыг дахиж нягтлах, хүүхдийн мөнгийг олгохдоо бэлэн мөнгөөр биш хуримтлалын хэлбэрээр олгох асуудлыг ажлын хэсэг анхаарах хэрэгтэй, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал төрийн худалдан авалтаар дотоодын үйлдвэрлэлээ дэмжсэн бодлогыг хэрэгжүүлэх, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн дийлэнх хувийг бүтээн байгуулалтад зарцуулахад хуваарилахгүйгээр тодорхой хувийг баялаг бүтээдэг, эдийн засгаа тэлдэг, татварын бааз суурийг нэмэгдүүлэх чиглэлд зарцуулах нь зүйтэй гэсэн саналуудыг гаргасан болно.

Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа төсвийн шинэчлэлийг үе шаттайгаар хэрэгжүүлж, төрийн байгууллагын ажил, үйлчилгээг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэхийг төсвийн бодлогоор дэмжиж байгаа нь зүйтэй талаар дурдаад цаашид төрийн худалдан авалтаар дотоодын бизнес эрхлэгчдийг дэмжих, өрийн хэмжээг нэмэгдүүлэх асуудлыг ажлын хэсэг дээр судлан үзэж бууруулахад анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг ойр ойрхон өөрчилж байгаа нь буруу, төсвийн тооцоолол, аргачлал дээрээ сайн ажиллаж, бодитойгоор төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн үзүүлэлтийг гаргахад анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж эдийн засгийг дэмжих 10 их наядын хөтөлбөрийн аж ахуйн нэгжүүдийг дэмжсэн хөрөнгө оруулалтын зээлийн зориулалтыг тодорхой болгож, шинээр үйлдвэр байгуулах, өргөтгөх чиглэлээр зээл олгоход анхаарах нь зүйтэй гэсэн саналуудыг гаргасан болно.


Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 69.2 хувийн саналаар дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ч.ХҮРЭЛБААТАР